

“ЕВРОП ДАХЬ ДҮРВЭГСДИЙН АСУУДАЛ”

Д.Алтай¹

Ч.Цэрэннадмид²

Abstract: *The number of forcibly displaced people worldwide reached almost 65 million at the end of 2014, the highest number in the past 70 years. Among these, 14.4 million were refugees, an increase of about 25 percent since the end of 2013. This increase is mostly due to the civil war in Syria and unrest throughout the Middle East, other regions, including parts of Africa and the Balkans, are also major sources of refugees. This article consists of following sections, namely: a/ Current state of the surge in refugee crisis in the Middle East; b/ Turkey’s role in the refugee crisis as transition country; c/ Challenges faced by European countries as a “recipient” countries;*

Хураангуй: 2016 оны 6-р сарын байдлаар дэлхий даяар нийт 65 сая хүн өөрийн орон гэрээс дүрвэн зугтахгаас өөр аргагүй байдалд хүрээд байна. Энэ нь өнгөрөгч 70 жилийн түүхэнд байгаагүй хамгийн өндөр тоо юм. Эдгээрээс 21 сая хүн дотоодын зөрчил мөргөлдөөн, иргэний дайны улмаас эх орноосоо дүрвэж, хөри зэргэлдээ улсууд руу, цаашилаад илүү тайван, баталгаат амьдралын орчин бүхий Европын улсууд руу дүрвэж байна. Тус өгүүлэлд Ойрхи Дорнод, Африкийн зарим орнуудаас хөри зэргэлдээ улс, Европын орнууд руу чиглэсэн их хэмжээний дүрвэгсдийн өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудал, дэлхий нийтийн анхаарал татсан асуудал болох дүрвэгсдийн асуудал, тэр дундаа Сирийн дүрвэгсдийн асуудлаар олон улсын хамтын нийгэмлэгийн зүгээс авч буй арга хэмжээ, олон улсын яриа хэлэлцээ, хамтын ажиллагааны талаар өгүүлэх болно.

Key words: *Civil war, internal conflicts, human rights, refugees, migrants, humanitarian crisis, international protections, UN Refugee Agency, Turkey, EU, terrorism, border protection, security issues.*

¹ Д.Алтай. ШУА-ийн Олон улсын харилцааны хүрээлэнгийн Дэлхийн бодлогын салбарын эрхлэгч, доктор Ph.D

² Ч.Цэрэннадмид. ШУА-ийн Олон улсын харилцааны хүрээлэнгийн ЭША, докторант

ЕВРОП РУУ ДҮРВЭГСДИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ.

Ойрхи дорнод, Африк болон өмнөд Азийн зарим улсад өрнөж буй улс төрийн хямрал, иргэний дайн, дотоодын зөрчил мөргөлдөөн нь Европын орнуудыг чиглэсэн дүрвэгч, цагаачдын урсгал ихээхэн өөрчлөгдөхөд хүргэж байна.

2016 оны 6-р сарын байдлаар дэлхий даяар нийт 65 сая хүн өөрийн орон гэрээс дүрвэн зугтахгаас өөр аргагүй байдалд хүрээд байна. Энэ нь өнгөрөгч 70 жилийн түүхэнд байгаагүй хамгийн өндөр тоо юм. Эдгээрээс 21 сая хүн дотоодын зөрчил мөргөлдөөн, иргэний дайны улмаас эх орноосоо дүрвэж, хөрш зэргэлдээ улсууд руу, цаашлаад илүү тайван, баталгаат амьдралын орчин бүхий Европын улсууд руу дүрвэж байна. Энэ тоо 2013 оны тоотой харьцуулахад 25 хувиар өссөн тоо юм.³ Сүүлийн гурван жилийн хугацаанд дүрвэгсдийн тоо ийнхүү огцом өссөн нь Сири улс дахь иргэний дайн, ойрхи Дорнод дахь бусад зөрчил, мөргөлдөөнөөс үүдэлтэй.

Өнгөрөгч 2015 оны байдлаар нэг сая орчим хүн Европын Холбооны улс руу дүрвэхээр албан ёсоор хүсэлтээ гаргасан байна. Энэ нь 2014 оны мөн үеэс даруй 5 дахин өссөн тоо юм. НҮБ-ын Дүрвэгсдийн асуудал хариуцсан Дээд комиссарын албаны тооцоолсноор эдгээр дүрвэгсдийн 84 хувь нь дайн, дотоодын зөрчил, мөргөлдөөнтэй газраас ирсэн хүмүүс байх бөгөөд тэдний дийлэнх олонх нь Сири, 20 хувь нь Афганистан, үлдсэн хувь нь Ирак, Эритрей, Сомали зэрэг улсаас ирсэн дүрвэгсэд байна⁴.

Зөвхөн Сирийн дүрвэгсдийн тоо 4 сая хол давсан бөгөөд эдгээр дүрвэгсдийн дийлэнх нь хөрш зэргэлдээ улсууд болох Турк, Ливан, Иордан руу дүрвэсэн байна. Эдгээр дүрвэгсдийн эх орноо орхин гарч буй үндсэн шалтгаанд дараах гурван асуудал багтаж байна:

Хүчирхийлэл: Сири улсад иргэний дайн эхэлснээс хойш, 400.000 гаруй хүн амь үрэгдээд байгаагийн дийлэнх нь энгийн иргэд байсан бол 14000 нь хүүхэд байсан гэж Сирийн Хүний эрх ТББ мэдээлсэн байна. Энэхүү иргэний дайнд гадны томоохон хүчнүүд нэгдсэнээр нөхцөл байдал улам хүндэрч байна.

³ The data are from the Office of the United Nations High Commissioner for Refugees (UNHCR).

Individuals applying for refugee status are designated as asylum seekers until they are granted that status.

⁴ <http://www.worldpoliticsreview.com/articles/17650/for-europe-integrating-refugees-is-the-next-big-challenge>

Дэд бүтэц: Эрүүл мэнд, боловсролын үйлчилгээ зэрэг нийгмийн үндсэн үйлчилгээг хүргэх дэд бүтэц байхгүй, эдийн засаг маш хүнд байдалд байна.

Аюулгүй байдал: Сайн сайхан ирээдүйг хүлээсэн ард түмний найдвар бараг үгүй болсон. Дүрвэгсэд хайртай бүхнээ алдаж, хүнд бэртэж, үгээр илэрхийлэхийн аргагүй хүчирхийллийн гэрч болсоор байна. АНУ-ын Төрийн департаментын мэдээлснээр дайн өдөөгч талууд жирийн иргэдийг хүчээр цэргийн албанд элсүүлж байгаа жишээ ч байгаа юм.

Ийнхүү дайн дажин, эдийн засгийн хүнд байдлаас зугтан Газар дундын тэнгисээр дамжин Европын орон руу дүрвэгсдийн тоо 2015 онд нэг сая болсон бол 2016 онд 250.000 дүрвэгсэд энэхүү аюултай аяллыг хийгээд байна. Харамсалтай нь Газар дундын тэнгисээр дамжин Европ хүрэх энэхүү аяллын явцад 3700 хүн амь үрэгдэж, алга болсон гэж НҮБ-ын Дүрвэгсдийн асуудал хариуцсан дээд комиссарын алба мэдээллээ. 2016 оны эхний 7-р сарын байдлаар мөн 3000⁵ гаруй дүрвэгсэд Газар дундын тэнгисээр дамжин Европ хүрэх аюултай аяллыг сонгоод байна.


ДҮРВЭГСДИЙН ДАМЖИН ӨНГӨРӨХ ТУРК УЛСЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Турк улс дэлхий дээрх хамгийн олон дүрвэгсэд хүлээн авсан улс болоод байна. Сири улсад иргэний дайн эхэлсэн 2011 оны 3 дугаар сараас өнөөг хүртэл Турк улс нийт 2.7 сая Сирийн дүрвэгч хүлээн авчээ⁶.

5 <http://www.aljazeera.com/news/2016/07/desperate-journeys-3034-refugees-die-months-160730100626791.html>

6 <http://data.unhcr.org/syrianrefugees/regional.php>

Зураг 1. Турк улсад бүртгэлтэй Сирийн дүрвэгсэд



2015 оны эцсийн байдлаар, Турк улсад ирсэн Сирийн дүрвэгсдийн 86 хувь нь Туркийн Сиритэй залгаа хил орчмын хотууд болон Станбул, Анкара зэрэг томоохон хотуудад амьдарч байгаа бол зөвхөн 14 хувь нь хил орчимд байрлах дүрвэгсдийн хуаранд байрлаж байна⁷.

Турк дахь Сирийн дүрвэгсдийн асуудал богино хугацаанд шийдэгдэх асуудал биш гэдэг нь нэгэнт тодорхой болсон тул Туркийн засгийн газар институцийн болон дэд бүтцийн шинж чанартай олон өөрчлөлтүүдийг хийж эхэллээ. Тухайлбал 2016 оны эхний хагаст Турк улсын Засгийн газар дүрвэгсдийн нийгмийн асуудлыг шийдэж, хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгоход чиглэсэн хууль тогтоомж батласан бөгөөд эдгээр зохицуулалтын дүнд дүрвэгсэд бүртгэл хийлгэснээс хойш 6 сарын дараа тус улсын газар нутаг дээр ямар нэг хязгаарлалтгүйгээр хөдөлмөр эрхлэх боломжоор хангагдах юм.

Турк улс, Европын Холбоо сүүлийн үед дүрвэгсдийн асуудлаар идэвхитэй хамтран ажиллаж эхэллээ. 2016 оны 3 дугаар сард Европын Холбоо, Туркийн Засгийн газар хооронд дүрвэгсдийн асуудлаар хамтран ажиллах гэрээ байгуулсан бөгөөд энэ гэрээгээр зохицуулах үндсэн асуудлуудын нэгдүгээрт Грекийн арлуудаар дамжин хууль бусаар ЕХ руу нэвтрэх оролдлогуудыг хязгаарлаж, хууль бус дүрвэгсдийг Турк улсын газар нутаг руу буцаан татах; хоёрдугаарт Турк улсад байгаа Сирийн дүрвэгсдээс ЕХ-ны гишүүн орнууд руу илгээх; гуравдугаарт Туркийн иргэдийг ЕХ-ны улсууд руу визгүй зорчих эрхээр хангах зэрэг асуудлууд багтаж байгаа юм.

⁷ IMF Discussion note: Refugee Crisis in Europe: Economic Challenges, page 8, January 2016

ЕХ, Турк хооронд байгуулсан энэхүү гэрээ хэрэгжиж эхэлснээр зарим зэрэг үр дүн гарч байна. НҮБ-ын мэдээлснээр энэ гэрээ хэрэгжиж эхлэхээс өмнө хууль бус дүрвэгчдийн тоо 150.000 байсан бол гэрээ хэрэгжиж эхэлсэн эхний гурван сард энэ тоо 8000 болтлоо буурсан байна.⁸

ЕВРОПЫН ОРНУУДЫН ӨМНӨ ТУЛГАРЧ БҮЙ СОРИЛТ БЭРХШЭЭЛ

ЕХ-ны гишүүн бүх улс НҮБ-ын Дүрвэгсдийн асуудлаарх 1951 оны Женевийн конвенцид нэгдэн орсон байдаг бөгөөд тус конвенц нь олон улсын дүрвэгсдийн асуудлыг зохицуулах хууль эрх зүйн тулгуур баримт бичиг юм. Иймээс энэхүү конвенцийг соёрхон баталсан улс бүр НҮБ-ын Дүрвэгсдийн асуудлыг хариуцсан байгууллагатай нягт хамтран ажиллах үүрэгтэй.

Хэдий тийм боловч Европ руу чиглэсэн дүрвэгсдийн урсгал сүүлийн жилүүдэд урьд өмнө байгаагүйгээр огцом нэмэгдэж байгаа энэ нөхцөлд ЕХ-ны гишүүн бүр олон улсын өмнө хүлээсэн үүрэг хариуцлагаа өөр өөрөөр тайлбарлаж, хэрэгжүүлж байна.

Африк, ойрхи Дорнодоос ирж буй дүрвэгсдийн тоо өнгөрөгч 2015 онд 1 сая хүрсэн бөгөөд хамгийн олон дүрвэгсэд хүлээн авсан улсад Герман, Унгар, Швед улс багтаж байна.

Гэхдээ Европын орнууд руу чиглэсэн дүрвэгсдийн урсгал Сирийн хөрш зэргэлдээ улсууд болох Турк, Иордан, Ливан зэрэг улсуудад ирсэн дүрвэгсдийн тоотой харьцуулахад харьцангуй бага буюу нийт дүрвэгсдийн ердөө 10 хувьтай тэнцэж байгаа юм⁹.

Дүрвэгсдийн дийлэнх олонх нь очсон улсдаа ажил хөдөлмөр эрхлэх сонирхолтой байдаг ч ЕХ-ны гишүүн орон бүрийн дүрвэгсдийг хүлээн авах, хөдөлмөрийн зах зээлд нэгтгэх дүрэм журам өөр, өргөдөл шийдвэрлэх хугацаа харилцан адилгүй байдаг нь хүндрэлтэй нөхцөл байдал бий болгож байна. Одоогоор ЕХ-ны ихэнх улс орон дүрвэгсдийг тусгай кампуудад байрлуулах эсвэл зарим хотуудад байршуулж эхэлсэн

⁸http://ec.europa.eu/dgs/home-affairs/what-we-do/policies/european-agenda-migration/proposal-implementation-package/docs/20160615/4th_report_on_relocation_and_resettlement_en.pdf

⁹ <http://data.unhcr.org/syrianrefugees/regional.php>

Европ дахь дүрвэгсдийн асуудал

боловч эдгээр хотын оршин суугчид зарим тохиолдолд дүрвэгсдийн эсрэг хүч хэрэглэх, дургүйцлээ илэрхийлэх хандлагууд гаргасаар байна.

Дүрвэгсдийн Европ руу чиглэсэн урсгалыг алан хядах бүлэглэл ашиглаж байгааг баталгаатай эх сурвалжаар нотлож чадаагүй боловч 2015 оны 11 дүгээр сард Парис хотноо болсон алан хядах ажиллагааг шалгах явцад халдлага үйлдсэн этгээдүүдийнх хоёр нь Сирийн дүрвэгсэдтэй хамт Грек улсаар дамжин Европ руу нэвтэрсэн болохыг тогтоожээ¹⁰. Цаашлаад ЕХ-ны зарим улс орны иргэдийн дунд дүрвэгсдийн талаарх сөрөг ойлголт, үзэл хандлага нэмэгдэх төлөвтэй байна. Жишээлбэл, 2015 оны 4 дүгээр сард Унгар улсад хийсэн олон нийтийн санаа бодлыг тандах судалгаагаар нийт судалгаанд хамрагдагсадын 46 хувь нь өөрийн оронд дүрвэгсдийг хүлээн авахгүй байх нь зүйтэй гэж үзсэн байна.

Огноо	Халдлага	Нас барсан	Бэртэж гэмтсэн	Байгууллага	Байршил
7/14/2016	Нице хот дах халдлага	86	464	ИУ Бүлэглэл	Франц
3/22/2016	Бруссел дэх халдлага	31	300	ИУ Бүлэглэл	Бельги
11/13/2015	Парис дахь халдлага	130	368	ИУ Бүлэглэл	Парис, Франц
1/7/2015	Чарли Хэбдо Халдлага And Nupercacher	12	11	ИУ Бүлэглэл	Парис, Франц
5/24/2014	Еврейн музейд болсон халдлага	4	0	ИУ Бүлэглэл	Бельги
7/18/2012	Бургас буудал дахь дэлбэрэлт	7	32	Хэзболла	Болгар
3/11/2012	Буудлага	8	0	Ал-Кайда / Jund Ал-Килафа	Франц

¹⁰ Европол – Алан хядах ажиллагааны нөхцөл байдал – цаашдын хандлага – 2016

7/22/2011	Норвеги дахь халдлага	77	319	Чоно бүлэглэл	Норвеги
8 халдлага		355	1494		

*Хүснэгт 1. 2011 – 2016 оны хооронд
ЕХ-ны улсуудад болсон алан хядах ажиллагаа*

ДҮГНЭЛТ

Юуны өмнө дүрвэгсдийн асуудал дэлхий нийтийн өмнө тулгарч буй хамгийн анхаарал татсан асуудал болоод байна. Энэ нь геополитик, иргэншил хоорондын болон бүс нутаг хоорондын харилцаанд олон сөрөг үр дагавар авчирсан ноцтой асуудал юм.

2016 оны 9-р сарын 19-ний өдөр НҮБ-ын үндэсний Ассемблейн хуралдаан дээр Дүрвэгсдийн асуудлаарх Нью-Йоркийн тунхаг нэртэй баримт бичиг баталсан бөгөөд энэхүү тунхагаар улс орнууд дүрвэгсдийн асуудлыг дэлхий нийтийн асуудал хэмээн үзэж, үүрэг хариуцлагаа хуваалцан, хамтран ажиллах болно гэдгээ тунхагласан юм.

Хоёрдугаарт, Бүгд найрамдах Турк улсын хувьд шашин, соёл, уламжлал ойролцоо, дүрвэгсэд суурьших, идээших бололцоо илүү учир дүрвэгсдийг татах хандлага илүүтэй байна. Туркийн тухайд исламын ертөнцийн дотоод зөрчил, шашны урсгал хоорондын зөрчил улам тод илэрвэл, бүс нутгийн хурцадмал асуудал бий болох магадлал өндөр байгаа нь анхаарал татаж байна.

Гуравдугаарт, Герман, Францын жишээнээс харахад Европ тивд терроризмын голомт бий болох эрсдэл нэмэгдэж байна. Европын уугуул иргэд, урьд өмнө байсан цагаачид болон шинээр дүрвэн очиж буй цагаачид хоорондын зөрчил маргаан хурцдах эрсдэлтэй.

Тиймээс юуны өмнө дүрвэгсдийн төрөлх улс оронд нь улс төрийн тайван байдлыг тогтоох, их гүрнүүдийн үүрэг оролцоог багасгах, улмаар тэднийг эх орондоо амар тайван аж төрөх бололцоо нөхцлийг бий болгох нь нэн чухал юм.

НҮБ болон ЕХ-ноос гаргасан дүрвэгсдийн талаарх хууль дүрэм, бодлогын баримт бичгүүдийг өнөө цагийн нөхцөл байдалд нийцүүлэн дахин хянан боловсруулах шаардлагатай байна. Нэгэнт ЕХ-ны

улсуудад дүрвэн ирсэн цагаачдын эрхийг хамгаалж, амьдрах орчин, хөдөлмөр эрхлэх боломжоор хангах асуудлыг бүс нутгийн болон олон улсын яриа хэлэлцээний механизмын замаар шийдвэрлэх нь зүйтэй.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

Хууль, эрх зүйн баримт бичиг

1. “Convention and protocol relating to the status of Refugees” by UN Refugee Agency, 1951
2. “The Dublin Regulation”, 2003
3. “Factsheet on the EU-Turkey Agreement”, Brussels, 19 March 2016
4. “ EUROPEAN UNION “Directive 2011/95/EU of the European parliament on standards for the qualification of third country nationals or stateless persons as beneficiaries of international protection, for a uniform status for refugees or for persons eligible for subsidiary protection, and for the content of the protection granted”, 2011
5. “New York Declaration” by UN General Assembly, 13 September 2016, A/71/L.1

Эрдэм шинжилгээний сэтгүүл

1. ORSAM – Center for Middle Eastern Strategic Studies “Syrian refugees in Turkey: Challenges to and opportunities for Longer-term integration”. №1, January 2016
2. IMF Discussion note: “Refugee Crisis in Europe: Economic Challenges”. January 2016.

Эрдэм шинжилгээний цахим сэтгүүл

1. “For Europe, Integrating Refugees Is the Next Big Challenge” by Judith Sunderland, Jan. 12, 2016, <http://www.worldpoliticsreview.com/articles/17650/for-europe-integrating-refugees-is-the-next-big-challenge>.
2. “Desperate journeys: 3,034 refugees die in seven months”, by Anealla Safdar, 30 July 2016 <http://www.aljazeera.com/news/2016/07/desperate-journeys-3034-refugees-die-months-160730100626791.html>

Албан ёсны статистик мэдээллийн цахим хуудас

UNHRC, THE UN REFUGEE AGENCY

Inter-Agency Information sharing portal

<http://data.unhcr.org/syrianrefugees/regional.php>

EUROPEAN COMMISSION

http://ec.europa.eu/dgs/home-affairs/what-we-do/policies/european-agenda-migration/proposal-implementation_package/docs/20160615/4th_report_on_relocation_and_resettlement_en.pdf

EUROPOL - European Union's law enforcement agency

Terrorism situation and Trend Report – 2016

https://www.europol.europa.eu/latest_publications/37